



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тосонцэнгэл сумын Мэргэжлийн боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/234/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Улиастай сум

2024 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын

Дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер : Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Аудитор: Г.Уранбаяр

Утас: 95183025

Цахим хаяг: gonchigdorjuranbayr@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2024.02.22 № 88
танай _____ -ны № _____ -т

ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН
МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Б.ГЭРЭЛТ-ОД -Д

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тосонцэнгэл сумын Мэргэжлийн боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Тосонцэнгэл сумын Мэргэжлийн боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тосонцэнгэл сумын Мэргэжлийн боловсролын сургууль нь спорт заалнаас олсон орлогыг санхүүгийн тайланд тусгаагүй, хөрөнгийн тооллогыг бүрэн хийгээгүй зэрэг алдаа зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2."Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ" 12.2.1."жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 14.4."Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.5."бүх орлого" гэснийг тус тус зөрчиж, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тосонцэнгэл сумын Мэргэжлийн боловсролын сургууль нь тайлант онд 1,717.8 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн бөгөөд 1,712.1 сая төгрөг зарцуулж, 5.6 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, хандиваар 92.5 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авсан байна. Тайлант онд 190.5 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 204.2 сая төгрөгийн материалыг баримтын дагуу зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Тосонцэнгэл сумын Мэргэжлийн боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн

Audit(D)Дүгнэлт/2024

өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар цалин давхардуулан олгосон зөрчил илэрлээ.

Бусад асуудлын хэсэг

Бараа материалын хөдөлгөөний бүртгэлийг буруу хийсэн, хөрөнгийн шинжтэй зүйлсийг бараа материал дансанд бүртгэсэн, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийг шаардах хуудсаар зарцуулсан, мэргэжлийн сургуулийн суралцагчдын хийсэн бүтээлийг орлогоор бүртгээгүй, зарж борлуулсан орлогыг тайланд тусгаагүй, үлдэх өртөггүй 279 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байгаа зэрэг алдаа байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Д.БАТ-УНДРАА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан****2023 оны 12 дугаар сарын 31****/төгрөгөөр/**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>69,912,711.06</u>	<u>92,876,447.84</u>
33	АВЛАГА	78,221.06	122,487.86
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	78,221.06	122,487.86
35	БАРАА МАТЕРИАЛ	69,834,490.00	92,753,959.98
351	Түүхий эд материал	3,295,000.00	3,295,000.00
35110	Тусгай зориулалттай материал	3,295,000.00	3,295,000.00
354	Хангамжийн материал	66,539,490.00	89,458,959.98
35410	Бичиг хэргийн материал	3,323,000.00	3,323,000.00
35420	Аж ахуйн материал	30,434,990.00	47,686,339.98
35460	Хүнсний материал	7,635,000.00	4,335,000.00
35470	Бусад хангамжийн материал	25,146,500.00	34,114,620.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,985,640,757.25</u>	<u>4,936,998,408.16</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,985,640,757.25	4,936,998,408.16
392	Биет хөрөнгө	4,640,151,257.25	4,591,508,908.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,321,755,965.65	5,321,755,965.65
39202	Хуримтлагдсан элэгдэл	-768,296,113.80	-884,440,129.68
39203	Авто-тээврийн хэрэгсэл	182,728,920.00	182,728,920.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-160,803,490.91	-174,299,605.83
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	469,765,939.33	579,776,155.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	-438,717,585.52	-454,729,367.50
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	171,141,749.30	171,141,749.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	-140,349,626.80	-154,035,169.11
39217	Ном	2,925,500.00	3,610,390.00
393	Биет бус хөрөнгө	345,489,500.00	345,489,500.00
39301	Програм хангамж	15,310,000.00	15,310,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-15,310,000.00	-15,310,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	345,489,500.00	345,489,500.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,055,553,468.31</u>	<u>5,029,874,856.00</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>7,434.00</u>	<u>18,934,176.98</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,434.00	18,934,176.98
413	Өглөг	7,434.00	18,934,176.98
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	7,434.00	362,234.98
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	18,571,942.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,055,546,034.31</u>	<u>5,010,940,679.02</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	5,055,546,034.31	5,010,940,679.02
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,844,058,313.76	4,844,058,313.76
51101	Өмч: - төрийн	4,844,058,313.76	4,844,058,313.76
512	Хуримтлагдсан үр дүн	-6,119,285.81	-50,724,641.10

51210	Өмнөх үеийн үр дүн	-6,119,285.81	-6,119,285.81
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-44,605,355.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	217,607,006.36	217,607,006.36
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,055,553,468.31	5,029,874,856.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,036,474,903.00	1,818,829,636.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,211,003.00	102,458,336.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,211,003.00	102,458,336.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,128,000.00	102,458,336.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,128,000.00	1,440,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	101,018,336.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,035,263,900.00	1,710,371,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	806,132,700.00	1,431,128,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	806,132,700.00	1,431,128,800.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	00.00	6,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	229,131,200.00	279,242,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	264,367,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,268,000.00	14,875,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	989,350,722.89	1,863,434,991.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	966,079,822.89	1,776,497,493.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	966,079,822.89	1,776,497,493.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	545,297,478.00	1,008,135,794.24
210101	Үндсэн цалин	480,305,483.00	659,742,536.05
210102	Нэмэгдэл	00.00	139,352,715.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	64,991,995.00	107,736,000.00
210104	Урамшуулал	00.00	101,304,543.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,962,041.00	127,123,064.21
210201	Тэтгэврийн даатгал	47,194,066.00	86,890,007.59
210202	Тэтгэмжийн даатгал	5,542,856.00	10,222,430.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,404,043.00	8,116,344.49
210204	Ажилгүйдлийн даатгал	1,068,383.00	1,971,140.42
210205	Эрүүл мэндийн даатгал	10,752,693.00	19,923,141.01
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	132,691,851.00	282,939,441.91
210301	Гэрэл, цахилгаан	6,275,651.00	13,127,641.91
210302	Түлш, халаалт	124,610,200.00	255,126,300.00
210303	Цэвэр, бохир ус	1,806,000.00	14,685,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,463,264.00	24,074,459.75
210401	Бичиг хэрэг	1,986,900.00	3,118,943.00
210402	Тээвэр, шатахуун	3,715,200.00	3,491,186.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,269,964.00	2,222,720.75

210404	Ном, хэвлэл	787,000.00	281,760.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,602,800.00	1,152,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,101,400.00	13,807,250.00
2105	Нормативт зардал	34,548,505.00	62,347,370.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	163,600.00	2,531,350.00
210502	Хоол, хүнс	29,508,905.00	53,908,420.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,876,000.00	5,907,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,500,100.00	23,907,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	841,600.00	10,791,600.00
210604	Урсгал засвар	5,956,000.00	13,115,700.00
2107	Томилот, зочны зардал	2,519,000.00	2,590,700.00
210702	Дотоод албан томилолт	2,519,000.00	2,590,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,292,350.00	9,500,658.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	7,375,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	839,500.00	1,727,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	452,850.00	397,458.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	157,805,233.89	235,878,705.09
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,998,640.00	76,541,250.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	142,806,593.89	159,337,455.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,270,900.00	86,937,498.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,709,900.00	63,083,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	7,472,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	28,709,900.00	54,906,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	704,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-5,439,000.00	23,853,898.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	23,853,898.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	00.09
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	00.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>47,124,180.11</u>	<u>-44,605,355.29</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,037,715,285.00</u>	<u>1,717,811,300.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>1,541,003.00</u>	<u>1,440,000.00</u>
120	Нийтлэг татварын бус орлого	1,541,003.00	1,440,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,128,000.00	1,440,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,128,000.00	1,440,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>1,036,174,282.00</u>	<u>1,716,371,300.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	806,132,700.00	1,431,128,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	806,132,700.00	1,431,128,800.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	00.00	6,000,000.00

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	230,041,582.00	279,242,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	264,367,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,178,382.00	14,875,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	857,262,953.00	1,699,676,410.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	857,262,953.00	1,699,676,410.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	833,992,053.00	1,612,738,911.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	546,776,813.00	1,000,966,370.27
210101	Үндсэн цалин	392,085,048.00	552,485,399.86
210102	Нэмэгдэл	66,094,073.00	247,994,899.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	60,872,000.00	107,889,071.45
210104	Урамшуулал	27,725,692.00	92,596,999.77
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,876,530.00	133,981,954.00
210201	Тэтгэврийн даатгал	51,665,043.35	91,135,237.76
210202	Тэтгэмжийн даатгал	5,574,123.08	10,626,358.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,449,238.66	8,612,546.51
210204	Ажилгүйдлийн даатгал	1,101,623.93	2,140,469.23
210205	Эрүүл мэндийн даатгал	11,086,500.98	21,467,342.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	132,691,851.00	264,367,499.91
210301	Гэрэл, цахилгаан	6,275,651.00	13,127,641.91
210302	Түлш, халаалт	124,610,200.00	236,554,358.00
210303	Цэвэр, бохир ус	1,806,000.00	14,685,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,893,764.00	24,074,459.75
210401	Бичиг хэрэг	1,986,900.00	3,118,943.00
210402	Тээвэр, шатахуун	3,605,200.00	3,491,186.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,269,964.00	2,222,720.75
210404	Ном, хэвлэл	1,117,000.00	281,760.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,333,700.00	1,152,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,581,000.00	13,807,250.00
2105	Нормативт зардал	34,548,505.00	59,047,370.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	163,600.00	2,531,350.00
210502	Хоол, хүнс	29,508,905.00	50,608,420.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,876,000.00	5,907,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,450,100.00	27,209,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,652,500.00	3,051,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	841,600.00	10,791,600.00
210604	Урсгал засвар	7,956,000.00	13,366,700.00
2107	Томилолт, зочны зардал	2,071,000.00	2,590,700.00
210702	Дотоод албан томилолт	2,071,000.00	2,590,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,740,350.00	9,500,658.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	7,375,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	839,500.00	1,727,600.00

210803	Даатгалын үйлчилгээ	900,850.00	397,458.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,943,140.00	91,000,499.98
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,943,140.00	91,000,499.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,270,900.00	86,937,498.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,709,900.00	63,083,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	7,472,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	28,709,900.00	54,906,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	704,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-5,439,000.00	23,853,898.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	23,853,898.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	00.09
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	00.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>180,452,332.00</u>	<u>18,134,890.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	18,134,890.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	18,134,890.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	18,134,890.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	18,134,890.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>00.00</u>	<u>-18,134,890.00</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,498,568,813.76	00.00	1,016,547,612.51	5,515,116,426.27
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,498,568,813.76	00.00	1,016,547,612.51	5,515,116,426.27
C07	Тайлант үеийн үр дүн	345,489,500.00	00.00	-202,727,130.46	142,762,369.54
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,844,058,313.76	217,607,006.36	-6,119,285.81	5,055,546,034.31
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,844,058,313.76	217,607,006.36	-6,119,285.81	5,055,546,034.31
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,844,058,313.76	217,607,006.36	-6,119,285.81	5,055,546,034.31
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-44,605,355.29	-44,605,355.29

D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,844,058,313.76	217,607,006.36	-50,724,641.10	5,010,940,679.02
-----	---------------------------------------	------------------	----------------	----------------	------------------

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,431,128,800.00	1,407,294,902.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,431,128,800.00	1,407,294,902.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,368,045,200.00	1,344,211,302.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,000,968,300.00	1,000,966,370.27
210101	Үндсэн цалин	552,485,400.00	552,485,399.86
210102	Нэмэгдэл	247,994,900.00	247,994,899.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	107,891,000.00	107,889,071.45
210104	Урамшуулал	92,597,000.00	92,596,999.77
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	141,996,000.00	133,981,954.00
210201	Тэтгэврийн даатгал	101,357,300.00	91,135,237.76
210202	Тэтгэмжийн даатгал	10,159,700.00	10,626,358.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,127,700.00	8,612,546.51
210204	Ажилгүйдлийн даатгал	2,031,900.00	2,140,469.23
210205	Эрүүл мэндийн даатгал	20,319,400.00	21,467,342.36
2104	Хангамж, бараа материалын зардал	15,785,100.00	15,779,349.75
210401	Бичиг хэрэг	3,052,300.00	3,118,943.00
210402	Тээвэр, шатахуун	3,615,900.00	3,291,186.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,701,100.00	2,222,720.75
210404	Ном, хэвлэл	972,400.00	966,650.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	918,600.00	1,152,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,524,800.00	5,027,250.00
2105	Нормативт зардал	72,704,000.00	56,972,370.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,532,300.00	2,531,350.00
210502	Хоол, хүнс	64,239,000.00	48,533,420.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,932,700.00	5,907,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,649,100.00	22,639,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,921,100.00	4,921,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	10,801,300.00	10,791,600.00
210604	Урсгал засвар	6,926,700.00	6,926,700.00
2107	Томилолт, зочны зардал	2,610,100.00	2,590,700.00
210702	Дотоод албан томилолт	2,610,100.00	2,590,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,752,100.00	4,700,658.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,576,500.00	2,575,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,727,600.00	1,727,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	448,000.00	397,458.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	106580500.00	106580499.98

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	485,200.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	106,095,300.00	106,580,499.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63083600.00	63083600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	63,083,600.00	63,083,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,472,900.00	7,472,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	54,906,700.00	54,906,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	704,000.00	704,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,431,128,800.00	1,407,294,902.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,431,128,800.00	1,407,294,902.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,431,128,800.00	1,407,294,902.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	56.00	56.00
620001	Удирдах ажилтан	02.00	02.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00
620003	Үйлчлэх ажилтан	37.00	37.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,295,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,295,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,295,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,980,000.00
210402	Тээвэр, шатахуун	200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,780,000.00
2105	Нормативт зардал	2,075,000.00
210502	Хоол, хүнс	2,075,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,440,000.00
210604	Урсгал засвар	6,440,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,800,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,800,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	15,215,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,215,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,215,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тосонцэнгэл сумын Мэргэжлийн боловсролын сургуул нь Техник, тусгай мэргэжлийн дунд боловсрол олгох үйл ажиллагааны хүрээнд “Удирдлагын зөв бодлого, оновчтой шийдвэр Эрүүл мэнд, зөв төлөвшил, хандлага, Багш нарын өргөн мэдлэг, хөдөлмөрч чанар, бүтээлч сэтгэлгээ Суралцагчдын сурах хүсэл, тэмүүлэл, санаачилга, Ая тухтай, аюулгүй орчин, Хамт олны нэгдмэл хүчин чармайлт, Үйл ажиллагааны шударга ёс, хариуцлага сахилга бат, дэг журмыг мөрдүүлэхэд оршино.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90.0 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Боловсролын салбарт хийж байгаа шинэчлэл, үйл ажиллагаа, төсөв санхүүг дэмжсэн шийдвэрийг Засгийн газар, салбарын яамнаас гаргаж мөрдүүлсэн байна. Тухайлбал:

1. Засгийн газрын 2023 оны 241 дугаар тогтоолоор “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээ” баталсан байна.
2. ЗГ-ын 2023 оны 165 дүгээр тогтоол - боловсрол, шинжлэх ухааны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай
3. ЗГ-ын 2023 оны 240 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт - төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын зөвлөл нь 2023 оны ажлын төлөвлөгөөндөө 11 ажил хийхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт бүрд удирдамж батлуулж, хяналтаар илэрсэн зөрчлийг арилгаж ажилласан байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тосонцэнгэл сумын Мэргэжлийн боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж, толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тосонцэнгэл сумын Мэргэжлийн боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 25,722.88 мянган төгрөгөөр буюу 5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	69,834.49	92,753.96	22,919.47
Үндсэн хөрөнгө	4,985,640.76	4,936,998.41	(48,642.35)
Нийт хөрөнгө	5,055,475.25	5,029,752.37	(25,722.88)
Өр төлбөр	7,434.00	18,934.18	11,500.18
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,055,546.03	5,010,940.68	(44,605.35)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,062,980.03	5,029,874.86	(33,105.17)

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайланд онд:

Бараа материал эхний үлдэгдэл 69,834.4 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 189,146.6 мянга, хандив тусламжаар 8,458.1 мянга, нийт 197,604.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 74,685.2 мянган төгрөгөөр тус тус хасагдаж, эцсийн үлдэгдэл 92,753.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 22,919.47 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр 18,134.8 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, Боловсролын ерөнхий газраас хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй 92,560.2 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч нийт 110,695.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Жилийн эцэст 4,936.9 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 159,337.4 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Богино хугацаат өр төлбөр 11,500.18 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь түлш халаалтын зардлын өр байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 44,605.35 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,434,128.8 мянган төгрөг, нийт зарлагыг 1,434,128.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,407,294.9 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,407,294.9 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 6,000.0 мянган төгрөгийн, туслах үйл ажиллагааны орлогоос 1,440.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,407,294.9 мянган төгрөг буюу 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс санхүүжих					
71804	Мэргэжлийн болосролын сургууль				
80101	Үндсэн үйл ажиллагаа	1,434,128.8	1,407,294.9		98.7%
	Дүн	1,434,128.8	1,407,294.9		98,7%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр санхүүжсэн 1 хөтөлбөрийн хүрээнд 2 арга хэмжээ хэрэгжүүлж 286,682.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 286,682.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

/Мянган төгрөг/

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Шууд гэрээ байгуулах	Байрны Хүүхдийн хоол хүнс	64,239.00	63,830.40
2	Шууд гэрээ байгуулах	Түлш халаалт	231,794.60	236,554.40
3	Шууд гэрээ байгуулах	Гэрэл цахилгаан	15,841.90	13,127.60
4	Шууд гэрээ байгуулах	Цэвэр, бохир ус	16,731.00	14,685.50
5	Шууд худалдан авалт	Урсгал засвар	70,648.70	76,450.30
6	Шууд худалдан авалт	Харилцаа холбооны зардал	2,701.10	2,222.72
7	Шууд худалдан авалт	Эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ	2,532.30	2,531.35
8	Шууд худалдан авалт	Урсгал зардал /Тогтмол гарах зардал/	1,249,520.70	1,245,325.43
9	Шууд худалдан авалт	Сургалтыг дэмжих бусад үйлчилгээ	63,722.00	63,083.60
	ДҮН		1,717,731.30	1,717,811.30

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тосонцэнгэл сумын Мэргэжлийн боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Хаан соёмбо аудит” ХХК-ийн гэрээт аудитор Г.Уранбаяр гүйцэтгэж, хяналтыг “Хаан соёмбо аудит” ХХК-ийн захирал Х.Диймаа анхан шатанд хянаж, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитын менежер Х.Болдбаатар нар хоёр дахь шатны чанарын хяналтыг, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа дараагийн шатанд хяналтыг хэрэгжүүлсэн.

Тосонцэнгэл сумын Мэргэжлийн боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Хаан соёмбо аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,207,173.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 33,107.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 24,830.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 29 зүйл заалтаар хяналтыг хэрэгжүүлж алдаа зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тосонцэнгэл сумын Мэргэжлийн боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 2 зөвлөмж өгөгдсөн бөгөөд биелүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	577.5	1	577.5	100
Албан шаардлага	1	2000.7	1	2000.7	100
Зөвлөмж	1	491,127.7	1	491,127.7	100
Нийт дүн	3	494,205.9	3	494,205.9	

Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант оны төгсгөлд дээд шатны төсөв захирагчаас цалин, нийгмийн даатгалын шимтгэл болон хоолны зардлуудад дээр төсөвт шаардлагагүй санхүүжилт нэмж олгосон байгааг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 42,953,880 төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ,

3.1 Зөвлөмж

5.2 Албан шаардлага

18,078.880 төгрөгийн хөрөнгийг ангилал буруу бүртгэсэн, сургуулийн спорт залны орлого 23,000,000 төгрөгийг санхүүгийн тайланд тусган харуулаагүй бэлэн мөнгөний гүйлгээний тайлан гаргаагүй мөнгөн кассын батласан хязгаарыг зөрчсөн, үндсэн хөрөнгийн бүртгэлд 1045 ширхэг үлдэх өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байгаа, 1,875,000 төгрөгийн цалин буруу тооцож олгосон зэрэг зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

5.3 Төлбөрийн акт тогтоогоогүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Ангилал буруу бүртгэсэн хөрөнгө	1	18,078.8			1	18,078.8						
Бэлэн мөнгөнийн тайлан бэлтгэн гаргаагүй санхүүгийн тайланд тусгаагүй орлого	1	23,000.0			1	23,000.0						
Үлдэх өртөггүй хөрөнгө	1	0			1	0						
Цалин буруу тооцож олгосон	1	1,875.0			1	1,875.0						
Дүн	4	42,953.8			4	42,953.8						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Дүн						
Нийт дүн						

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

ОГНОО: 2024-02-22

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.БОЛДБААТАР

ОГНОО: 2024-02-22

АХЛАХ АУДИТОР

Ц.ОЮУНСУВД

ОГНОО: 2024-02-22

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ГЭРЭЭТ АУДИТОР

Г.УРАНБАЯР

ОГНОО: 2024-02-22

